



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 9/421

Мөрөн сум

Инженерийн шугам сүлжээний ажил  
хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2. 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилгад дулааны шугам татах ажлыг хүлээж авах ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүдэд:  
Х.Даваасүрэн

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Ж.Жавзанпагма

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Д.Аюушжав

(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Ж.Нацагдорж

(Онцгой байдлын газрын Гал, түймрийн хяналтын улсын байцаагч)

Ж.Улаанбаатар

(“Хөвсгөл барилга захилагчийн хяналтын төв” ААТҮГазрын хяналтын инженер)

М.Алтаншагай

(“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн шугам сүлжээний ашиглалтын инженер)

Д.Сүхээ

(“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн Ерөнхий инженер)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Н.Уганцэцэг

(“Итгэлт чандмань” ХХК-ийн Захирал )

671011011

2.

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Г.Цээпил

(“Туурайн тамга” ХХК-ийн Захирал )

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Я.Эрхэмбаяр

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав

(Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Инженерийн шугам сүлжээний ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Инженерийн шугам сүлжээний ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй инженерийн шугам сүлжээний ажлыг хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



ШИДЭРБАЯСГАЛАН